



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ОРА-2024/01/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Эрдэнэт хот 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Оргилмөрөн Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.03.25 № 92

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.ЗОРИГТБАЯР ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Жаргалант сумын 2023 оны төсвийн орлогыг сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор татварын орлогыг 1,164,230.6 мянган төгрөгөөр тодотгон баталж, гүйцэтгэлээр 1,273,582.3 мянган төгрөг бүрдүүлсэн байна. Төсвийн 5 нэр төрлийн орлого 41,381.6 мянган төгрөгөөр тасарч, 10 нэр төрлийн орлого 150,960.6 мянган төгрөгөөр давж, нийт дүнгээр төсвийн орлого давж биелсэн байна.

#### Аудитын гол асуудал

Жаргалант сумын уурын зуухыг Засаг даргын тамгын газарт хариуцуулан ажиллуулж байгаад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор "Жаргалант ус, дулаан түгээх станц" хувьцаат компанийг байгуулсантай холбоотойгоор 2022 оны 09 сараас энэхүү компанид үйл ажиллагааг нь шилжүүлж, санхүүгийн тайланг нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэсэн байна.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын төсвийн байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжиж босоо тогтолцоотой болсон тул сургууль, цэцэрлэг, эмнэлэг,

соёлын төвийн балансын үзүүлэлтүүд холбогдох төвлөрүүлэн захирагчдад шилжиж, эдгээр байгууллагууд орон нутгаас олгож буй санхүүжилтийн хүрээнд орлого, зардал бүртгэж нэгтгүүлж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,594,383.2</b>	<b>2,744,381.9</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	516,346.0	1,560,324.1
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	124,932.5	176,931.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	863,224.7	957,566.8
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	89,880.0	49,560.0
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>9,987,171.7</b>	<b>11,886,160.7</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	9,987,171.7	11,886,160.7
39200	Биет хөрөнгө		9,960,797.2	11,837,457.4
39300	Биет бус хөрөнгө	13	26,374.6	48,703.3
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>11,581,554.9</b>	<b>14,630,542.6</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		355,080.0	375,303.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	355,080.0	375,303.2
41300	Өглөг	17а, 17б	355,080.0	375,303.2
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>11,226,474.9</b>	<b>14,255,239.4</b>
51	Засгийн газрын хувь оролцоо		11,226,474.9	14,255,239.4
51100	Засгийн газрын оруулсан капитал		715,438.1	715,438.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		4,172,689.5	4,809,936.4
51200	Хуримтлагдсан үр дүн		5,139,017.0	7,530,534.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,199,330.3	1,199,330.3
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>11,581,554.9</b>	<b>14,630,542.6</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>13,773,716.5</b>	<b>14,048,146.1</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>497,952.3</b>	<b>1,273,809.6</b>
110	Орлогын албан татвар		322,585.2	1,022,412.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		322,585.2	1,022,412.4
113	Хөрөнгийн албан татвар		104,956.7	126,038.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		70,410.4	125,358.6
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1а, 1б</b>	<b>5,473,653.5</b>	<b>1,676,912.6</b>
120	Нийтлэг татварын бус орлого		5,473,653.5	1,676,912.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		7,802,110.7	11,097,423.9
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>9,277,325.5</b>	<b>8,313,953.3</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9,277,325.5	8,313,953.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		6,586,241.6	8,253,615.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		789,327.2	1,044,340.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		98,647.2	128,352.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		535,815.3	159,439.4
2104	Хангамж, бараа материалын зардал		3,335,184.8	3,106,166.4
2105	Нормативт зардал		0.0	3,534.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал		440,458.4	385,957.6
2107	Томилолт, зочны зардал		2,088.0	4,004.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		402,087.3	1,202,267.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		982,633.3	2,219,553.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,691,083.9	60,338.0
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>4,496,391.1</b>	<b>5,734,192.8</b>
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>7,562,456.7</b>	<b>3,342,675.3</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		<b>-3,066,065.7</b>	<b>2,391,517.5</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>10,122,118.1</b>	<b>0.0</b>	<b>10,122,118.1</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,267.0	0.0	-2,267.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,119,851.1	0.0	10,119,851.1
7	Өмчид гарсан өөрчилөлт	4,172,689.5	0.0	4,172,689.5
9	Тайлант үеийн үр дүн	-3,066,065.7	0.0	-3,066,065.7
10	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>11,226,474.9</b>	<b>0.0</b>	<b>11,226,474.9</b>
11	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>11,226,474.9</b>	<b>0.0</b>	<b>11,226,474.9</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,226,474.9	0.0	11,226,474.9
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	637,247.0	0.0	637,247.0
19	Тайлант үеийн үр дүн	2,391,517.5	0.0	2,391,517.5
20	<b>2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>14,255,239.4</b>	<b>0.0</b>	<b>14,255,239.4</b>

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>8,660,997.2</b>	<b>12,993,674.5</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>497,952.3</b>	<b>1,273,809.6</b>
110	Орлогын албан татвар		322,585.2	1,022,412.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		322,585.2	1,022,412.4
113	Хөрөнгийн албан татвар		104,956.7	126,038.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		70,410.4	125,358.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		5,034.1	7,888.8
1181	Газрын төлбөр		44,406.2	112,407.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		20,970.0	5,062.7
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>340,168.4</b>	<b>622,441.0</b>
120	Нийтлэг татварын бус орлого		340,168.4	622,441.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>7,822,876.5</b>	<b>11,097,423.9</b>
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>5,439,533.4</b>	<b>3,712,985.8</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>5,439,533.4</b>	<b>3,712,985.8</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,729,803.4	3,648,082.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		859,592.6	1,247,091.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		117,583.5	191,483.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		650,164.3	221,787.2
2104	Хангамж, бараа материалын зардал		239,794.1	256,076.6
2105	Нормативт зардал		18,363.6	9,940.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		470,889.7	434,291.6
2107	Томилолт, зочны зардал		2,088.0	4,004.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		303,954.2	749,282.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		67,373.4	534,125.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>2,709,730.0</b>	<b>64,903.0</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>		<b>3,221,463.9</b>	<b>9,280,688.8</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		<b>0.0</b>	<b>36.7</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>3,091,043.2</b>	<b>8,123,347.4</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>3,091,043.2</b>	<b>8,123,347.4</b>
2200	Дотоод эх үүсвэрээр		3,091,043.2	8,123,347.4
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>		<b>-3,091,043.2</b>	<b>-8,123,310.7</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>		<b>-100.0</b>	<b>-113,400.0</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>		<b>100.0</b>	<b>113,400.0</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>		<b>130,320.6</b>	<b>1,043,978.1</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		386,025.4	516,346.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		516,346.0	1,560,324.1

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>12,723,135.8</b>	<b>11,337,774.8</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	2,986,403.5	2,766,414.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,903,644.3	2,717,129.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,104,817.1	1,023,002.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,693.3	125,798.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	622,742.5	542,661.4
Хангамж, бараа материалын зардал	179,238.4	178,775.2
Нормативт зардал	9,400.0	9,400.0
Эд хогшил, урсгал засварын зардал	457,843.2	457,839.2
Томилолт, зочны зардал	5,690.0	4,004.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	275,763.0	268,191.9
Бараа үйлчилгээний бусад зардал	107,456.8	107,456.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,759.2	49,284.3
Бусад урсгал шилжүүлэг	82,759.2	49,284.3

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,509,912.1	8,457,960.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	226,820.2	113,400.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>12,723,135.8</b>	<b>11,535,928.4</b>
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,858,946.2	4,858,946.2
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,304,275.3	6,588,749.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	559,914.3	88,233.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		238,782.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		436,936.1
БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.0	0.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.1	0.1
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.1	0.1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>158,379.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>158,379.6</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,630.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,337.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,554.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	46,566.5
2105	Нормативт зардал	540.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,475.7
2107	Томилолт, зочны зардал	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,276.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,880.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,749.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,163.5
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,585.7</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>158,379.6</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	158,379.6
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.0</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 56,978.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 6,963.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 50,015.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд /E-report/ системээр нийт 10 байгууллага нэгтгэгджээ. Боловсрол, соёл, эрүүл мэндийн 4 байгууллага нь босоо тогтолцоотой болсон тул балансын үзүүлэлтүүд шилжиж, орон нутгаас авсан санхүүжилтийн хүрээнд орлого, зардлаа тайлагнаж байна.

Дүгнэлт гаргасан 4 байгууллагад өөрчлөлтгүй санал дүгнэлт өгсөн байна.

### **3.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### **3.2 Албан шаардлага**

Сумын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 1.2.17-д баталсан "Иргэдийн спортын их наадмыг зохион байгуулах зардал"-ыг 6,963.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан тул алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сумын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын зарцуулалтыг эрхийг баталсан төсвийн дагуу нээгээгүй байна.

Энэ нь Төвийн тухай хуулийн 37.1-д "Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ", 37.1.8-д төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аас баталсан төвийн дагуу холбогдох зардлын зарцуулалтыг эрхийг нээх, хяналт тогтоох.

#### **2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сумын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний "Хөдөө аж ахуйн барилга байгууламж" арга хэмжээг анх 3,400,000.0 мянган төгрөгөөр төсөвт өртгийг баталж НТШ-аар гүйцэтгэгчийг сонгож 3,349,985.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан бөгөөд сумын төсвийн тодотголоор уг арга хэмжээний төсвийг ХАА-ны хэмнэлт 50,015.0 мянган төгрөгөөр бууруулан тодотгож, уг хэмнэлтийг бусад хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардалд баталсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.3-д "хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн тодотголд оруулан бусад арга хэмжээнд төлөвлөж зарцуулахгүй байх.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жар. Засаг дарга	3	56,978.8			1	6,963.8	2	50,015.0				
Жар.ЗДТГ	6	29,061.1	2	6,847.0	1	0.0	3	22,214.1				
Жар.ИТХ	5	5,432.7	2	1,993.7			3	3,439.0				
Жар.ОНХСан	1	6,267.5					1	6,267.5				
Жар.Хоршоо хөгжүүлэх сан	2	3,880.4	1	3,480.4			1	400.0				
Жаргалант ус, дулаан түгээх станц ОНӨХК	12	6,104.2	7	6,104.2			5	0.0				
<b>Дүн</b>	<b>29</b>	<b>107,724.7</b>	<b>12</b>	<b>18,425.3</b>	<b>2</b>	<b>6,963.8</b>	<b>15</b>	<b>82,335.6</b>				

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	4	2	2		2			
2	ОНӨААН	1	1			1			
3	ТТЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>6</b>	<b>4</b>	<b>2</b>		<b>1</b>			